



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2019.08.19 № 19

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Асуулга хүргүүлэх тухай

Улс орныхоо эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, үндэсний аж үйлдвэр, шинэ технологи, инновацийн салбараа хөгжүүлэх замаар ард иргэдээ тогтвортой ажлын байр, орлоготой болгох зорилгоор Улсын Их Хурлаас

- Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого – 2010
- Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал – 2012
- Ногоон хөгжлийн бодлого - 2014
- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030
- Монгол улсын Засгийн Газрын үйл ажиллагааны 2016-2020 оны мөрийн хөтөлбөр зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг баталж, хэрэгжүүлэх чиг үүргийг Засгийн газруудад өгч ирсэн.

Мөн Улсын Их Хурлаас “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, үндэсний аж үйлдвэрийн салбараа төсвийн худалдан авалтаар дэмжиж ажиллах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж өгөөд байгаа энэ үед “Сити паблик транспорт корпорейшн” ХХК-ийн захиалгаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний хөгжлийн газраас “Байгаль орчинд ээлтэй, нэгдсэн ухаалаг систем бүхий нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл” нэртэй 1450 цахилгаан автобусыг БНХАУ-аас концессоор худалдан авахаар зэхэж байна.

Монгол Улсын нийтийн тээврийн салбарт төрийн болон гадаадын аль нэг улсын ноёрхлыг тогтоож, өнөөдрийг хүртэл тус салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дампууруулж, төр хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг тасалдуулах ажил хийж байгаад харамсаж байгаагаа илэрхийлье.

Дотоодын зах зээлийн эрэлт дээр үндэсний шинэ технологи бүхий машин байгууламжийн цоо шинэ салбараа хөгжүүлж, ард иргэдээ тогтвортой ажлын байр, орлоготой болгох талаар санаачлагатай ажиллахын оронд гадаад улс орны аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын төсвийн худалдан авалтаар дэмжиж, улс орныхоо эдийн засаг, санхүүгийн чадавхийг сулруулж, өрийн таазыг 1.0 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх энэхүү үйлдлээ таслан зогсоохыг хүсэж байна.

0000000087

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуулгыг хүргэж байна.

1. 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн Газрын 59 тоот тогтоолоор 2019 оныг “Эх оронч худалдан авалтын жил” болгон зарласан. Энэ тогтоолын дагуу авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай;
2. 2016 оны УИХ, НИТХ-ын сонгуульд оролцсон МАН-ын мөрийн хөтөлбөр болон Засгийн Газар, Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Үндэсний үйлдвэрлэгчдийн 400 автобусаар нийтийн тээврийн парк шинэчлэх” заалтын хэрэгжилтийн талаар;

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсохыг Танаас хүсье!

Хавсралт: 2 хуудас

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.БАТЗАНДАН

Л.БОЛД

0000087



ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А-103

Улаанбаатар хот

О.Ичкигорлоо

Үндэсний хөгжлийн газрын
саяргачаар, үндэсний газрын
ахлах мэргэжилтэн

Хосор Төслийн Концесс Ойгох Уралдаант Шалгаруулахыг Засгийн Уулс
Төлсөмжийн Даруу Зөмжсөн Байгуулж, Концессын Гэрээний Төслөгч Саяргачаар
Хамт Танилцуулахыг Комиссын Дарга Ю.Мөнхтөр-а Уурга Бэлтгэсэн

ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

Комисс томилох тухай

Концессын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.10, Засгийн газрын агентлагийн
эрх зүйн Байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6.4, Засгийн газрын 2019 оны
48 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн
ТУШААХ нь.

1. Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн
концессын зүйлийн жагсаалт" дахь "Байгаль орчинд эзлэх, нэгдсэн утгалаг систем
бүхий нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл"-ийн концесс ойгох урлаг-дээлт шалгаруулалтын
Барил Бичиг боловсруулах, зарлах, оролцох болон төслийн санал үнэлэх шалгарсан
оролцолтой концессын гэрээний хэлэлцээр хийх, санал дүгнэлт гаргах зүйл комиссыг,
дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Комиссын дарга: О.Мөнхтөр Үндэсний хөгжлийн газрын Төр, хувийн
хэвшлийн түмшлэлийн хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: Г.Содбаяр Үндэсний хөгжлийн газрын Төр, хувийн
хэвшлийн түмшлэлийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн
- Глишүүд
- Г.Түдэндорж Сэнгийн яамны Төсвийн хөрсөгч
орчуулалтын газрын дарга
 - Ц.Уранчимэг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны
Цэвэр технологи, хөрөнгө оруулалт,
үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
 - Г.Өлзийбаяр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын
Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
 - П.Мөнхбат Зам, тээврийн хөгжлийн яамны Авто
тээврийн бодлогын хэрэгжлийг
зохицуулах газрын агаар, орчны бэхрхдрөл
хариуцсан мэргэжилтэн
 - Б.Эрдэнэтүвш Зам, тээврийн хөгжлийн яамны Авто
тээврийн бодлогын хэрэгжлийг
зохицуулах газрын тээврийн ухаалаг
систем, мэдээллийн сан хариуцсан
мэргэжилтэн
 - Б.Түмэндэлгэр Үндэсний хөгжлийн газрын Судалгаа,
шинжилгээний газрын ахлах мэргэжилтэн

Төслийн сэнхүүжлтийн тухай мэдээлэл/азалээр бол аль улсынх, банкнаас:
Төслийн анхны хөрөнгө оруулалтыг Хятадын хөгжлийн банкны азалээр санхүүжүүлэхээр тусгасан.

Дүгнэлт:

Байгаль орчинд ээлтэй, нэгдсэн ухаалаг систем бүхий нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл" нь хөгжлийн бодлогын бичиг баримтуудтай нийцэж байгаа бөгөөд хэрэгжүүлэгч компани нь төслийн эдийн засаг, нийгмийн үр ашг, ач холбогдлыг тооцон, төсөлнд тусгасан байна. Төслийн бичиг баримтыг судалж үзсэний үндсэн дээр уг төслийг хэрэгжүүлэхийг зарчмын хувьд дэмжиж байна.

Санал: Манай албаны зүгээс дараах саналтай байна. Үүнд:

1. Зөрдөл, үр ашгийг тооцолоходоо нийтийн тээврийн тарифыг 30 жилийн хугацаанд өөрчлөхгүй, тогтвортой байхаар тусгасан байна. Төсөл хэрэгжих 30 жилийн хугацаанд тариф өөрчлөхгүй хатуу нөхцлөөр концессын гэрээ байгуулах боломжтой эсэхийг тодруулах;
2. Нийтийн тээврийн салбар нь стратегийн чухал ач холбогдолтой салбар тул төсөл хэрэгжүүлэгч компани, түүний хөрөнгө оруулагчдын талаар нэрийвчлэн судлах шаардлагатай боловч мэдээлээ ирүүлээгүй байгааг анхаарах;
3. Нийслэлийн нийтийн тээврийг хятадын нэг компаниас бүрэн хамааралтай болгох эрсдэл ажиглагдаж байгаа тул Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дүгнэлт гаргуулах;
4. Уг төсөл нь Улаанбаатар хотын агаарын бохирдол болон авто замын түгжрэлийн бууруулахад төдийгүй тус салбарт ажилладаг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлэхээр байгаа тул Нийслэлийн эрх бүхий байгууллагаас, мөн тээврийн салбарт томоохон ахиц гарах төсөл учраас тээврийн хөгжлийн асуудал харуулсан Зам тээврийн хөгжлийн яамнаас дүгнэлт гаргуулах;

Ханасан:

Боловсруулсан:

Хаанаас, хэнээс: Судалгаа шинжилгээний алба

Хэнд: Концесс, төр хувийн хэвшлийн түншлэлийн албанд

Утга: Дүгнэлт, санал хүрүүлэх тухай

Огноо: 2018.11.28

Төслийн нэр: "Байгаль орчинд ээлтэй, нэгдсэн ухаалаг систем бүхий нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл"

Төсөл хэрэгжүүлэгч: "Сити пাবлик транспорт корпорэйшн" ХХК

Төсөл ирүүлсэн байгууллага: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Бодлогод нийцэж байгаа эсэх: Бодлогод нийцэж байна. Тухайлбал:

- МУ-ын Ногоон хөгжлийн бодлого: 6.5 Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, найдвартай, эрсдэлгүй нийтийн тээврийн төрөл, үйлчилгээг хөгжүүлж, ирээд тав тухтай зорчих орчныг бүрдүүлэх;
- Агаар орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ авах;
- ялгарах бохирдуулах бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах;
- Төрөөс өвтгээврийн салбарт баримтлах бодлого (2018-2026): 2.3.5.3. хот доторх болон хот орчмын тээврийн үйлчилгээний паркыг байгалийн болон шингэрүүлсэн шатдаг хий, цахилгаан, байгаль орчинд ээлтэй бусад эх үүсвэрээр ажилладаг, тээгээрийн хосоллол хэрэглээ бүхий өвтгээврийн хэрэгслээр шинэчлэх;
- МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр: 2.22.Эрэлтэд нийцсэн, хүрээлэн байгаа орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлэх
- Улаанбаатар хотын 2020 он хүртэлх ногоон хөгжлийн стратеги, төлөвлөгөө: Зорилт 2.1. Нийтийн тээврийн хэрэглээг нэмэгдүүлэх: 2.1.3. Парк шинэчлэлтийг үргэлжлүүлэх, одоо ашиглаж буй том оврын автобусыг утаа ялааруулалт баагаатай шинэ автобусаар солих ажлыг үргэлжлүүлэх;

Асуудал харуулсан төрийн захиргааны төв байгууллагын санал/дэмжсэн/дэмжээгүй бол цагаард:
Байгаль орчин, аялал жуулчлалын яам дэмжин ажиллаж байгаа тухай албан бичиг ирүүлсэн.

Хөрөнгө оруулалтын төрөл /концесс, улсын төсвийн, хувийн хөрөнгө оруулалтын аль нь болох:
Концесс: Шинэчлэн сайжруулах – ашиглах – шилжүүлэх

ТЭЗҮ, ТЭЗҮС шаардлага хангаж байгаа эсэх:

- Бизнес төсөл ирүүлсэн, Төслийн боловсруулалт шаардлага хангаасан.

Гүйцэтгэгч компанийн тухай /аль улсын хөрөнгө оруулалттай/:

- Компанийн танилцуулга, мэдээлэл ирүүлээгүй.

Хамтрагчтай бол түүний мэдээлэл:

- Мэдээлэл ирүүлээгүй

МАН-ын мөрийн хөтөлбөр

2016 оны 6 сарын 13



БНД ХАМГДАА

ИРГЭДЭЭ ЯДУУРЛААС АВАРЧ

**ЭДИЙН ЗАСГАА ХЯМРАЛААС
ГАРГАЖ**

ЭХ ОРНОО ӨРНӨӨС САЛГАЖ

ТӨРИЙН ДАМШУУРЛЫГ ЗАСЧ

**ТЭГШ ЖУРАМТ, БАЯН
ХУЧИРХЭГ**

МОНГОЛОО ЦОГЦЛООЖ

ЧАДНА

**5.3.3 Аюулгүй, найдвартай,
их багтаамжтай нийтийн
тээврийг хөгжүүлэн,
үндэсний үйлдвэрлэгчдийн
бүтээсэн 400-аас доошгүй
автобус троллейбусаар парк
шинэчлэнэ.**